



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 437

Улаанбаатар хот

Инженерийн баг, хяналтын
инженер томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалт, ИНД-171.79(а).6.2 "Байгууламжийг суурилуулах ба ажилд хүлээн авах журам"-ын 6.2.4.1, 6.2.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нисэхийн ажиглалтын үйлчилгээний IRS-20MP/S ажиглалтын радиолокаторын шалгалтын транспондрийг Төв аймгийн Алтанбулаг суман дахь "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨК-ний байранд шилжүүлэн суурилуулах, цахилгаан хангалтын тасралтгүй тэжээлийн төхөөрөмжид холбох, турших ажлыг гүйцэтгэх инженерийн баг, хяналтын инженерийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Инженерийн багийн
ахлагч: Д.Тулга

Техник хангалт, навигацийн үйлчилгээний
албаны Ажиглалт автоматжуулалтын
хэсгийн Техник ашиглалтын тасгийн ахлагч
инженер

Гишүүд: Б.Золбоо

Техник хангалт, навигацийн үйлчилгээний
албаны Ажиглалт автоматжуулалтын
хэсгийн техник ашиглалтын тасгийн
инженер

Б.Зориг

Техник хангалт, навигацийн үйлчилгээний
албаны Ажиглалт автоматжуулалтын
хэсгийн техник ашиглалтын тасгийн
инженер

Хяналтын
инженер: Д.Доржмягмар

Техник хангалт, навигацийн үйлчилгээний
албаны Ажиглалт автоматжуулалтын
хэсгийн техник ашиглалтын тасгийн ахлагч
инженер

2. Тоног төхөөрөмжийг шилжүүлэн суурилуулж, цахилгаан хангалтын тасралтгүй тэжээлийн төхөөрөмжид холбох, турших ажлыг гүйцэтгэх үед үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаанд нөлөөлөхгүй, нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн хангахаар зохион ажиллахыг инженерийн багийн ахлагч Д.Тулга, хяналт тавьж ажиллахыг хяналтын инженер Д.Доржмягмар нарт тус тус үүрэг болгосугай.

3. Инженерийн баг, хяналтын инженерт байнгын хяналт тавьж ажиллахыг
Техник хангалт, навигацийн үйлчилгээний алба /Д.Баяртогтох/-нд үүрэг
болгосугай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА



The image shows a handwritten signature in black ink over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text: "ТЭХНИК ХАНГАЛТ, НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА" (Department of Technical Support and Navigation Services) and "Улаанбаатар" (Ulaanbaatar). The signature is written in a cursive style.

Б.АЛТАНЦОМ